



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 05 сарын 9 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Харьюу овогтой Бум-Эрдэнийг Англи улсын Лондон хотын Холборн коллежийн магистрантурт хуулийн чиглэлээр, Дэмбэрэл овогтой Баясгаланг АНУ-ын Колорадогийн Их сургуулийн магистрантурт технологийн чиглэлээр, Ганжууржав овогтой Эрдэнэбаясгаланг АНУ-ын Колорадогийн Их сургуулийн магистрантурт байгаль орчны чиглэлээр 2 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 349 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2002-319

САЙД

А.ЦАНЖИД